[View in browser]




planetGOLD Монгол төлийн хамгийн сүүлийн мэдээллийн товхимолтой танилцана уу
Бид бичил уурхайд алт боловсруулахад мөнгөн усны хэрэглээг халах, бичил уурхайн салбарыг албажуулах чиглэлээр ажилладаг төсөл бөгөөд алт нийлүүлэлтийн оролцогч талууд болох уурхайчид, алтны худалдаачид, орон нутгийн болон Монгол Улсын засгийн газар, иргэний нийгэмтэй хамтран ажилласнаар алслагдсан орон нутгийн эдийн засгийн чухал боломж болох бичил уурхайн үйл ажиллагааг тогтвортой сайжруулах, алтны нийлүүлэлтийг зохицуулах дүрэм, журмыг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Цаашид төлийн талаарх мэдээллийг цаг тухайд нь тогтмол хүлээн авах хүсэлтэй бол бидний Facebook болон Twitter хуудсыг дагаарай.

# Сургалт




2022 оны хоёрдугаар улиралд planetGOLD төсөл бичил уурхайчдад болон төрийн албан

хаагчдад зориулсан олон төрлийн сургалт зохион байгууллаа.

### Говь-Алтай аймгийн бичил уурхайчдад багц сургалт зохион байгуулав

planetGOLD Монгол төслийн баг Монголын бичил уурхай нэгдсэн дээвэр холбоо (МБУНДХ)-той хамтран багц сургалтын хөтөлбөр боловсруулж 2022 оны 4-р сард Говь-Алтай аймгийн 134 бичил уурхайчдад (81 эрэгтэй, 51 эмэгтэй) 6 өдрийн сургалт зохион байгуулав. Сургалтын хөтөлбөрт дараах сэдвүүд багтав.:

- Хариуцлагатай бичил уурхай
- Байгаль орчны хариуцлага, нөхөн сэргээлт
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, мөнгөн усны хор хөнөөл
- Бизнес, санхүүгийн менежмент
- Жендер, хүний эрх





### Төрийн албан хаагчдад жендэрийн сургалт зохион байгуулав

planetGOLD төсөл, МБУНДХ болон Өөрчлөлтийн төлөө эмэгтэйчүүд ТББ нар хамтран "Жендэр, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт" сэдэвт сургалтыг 2022 оны 5, 6-р саруудад Говь-Алтай, Сэлэнгэ, Ховд аймгийн төрийн албан хаагчдад зориулан зохион байгууллаа. Уг сургалтад аймгуудын ЗДТГ, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар /Экологийн цагдаа/, Ус цаг уур орчны шинжилгээний төв гэх мэт байгууллагын 63 албан хаагчид (34 эрэгтэй, 29 эмэгтэй) оролцлоо. Оролцогчид уг сургалтаар дамжуулан жендэр, жендэрийн эрх тэгш байдлын талаар суурь мэдлэг, Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын талаар ерөнхий ойлголттой болохын зэрэгцээ жендэрийн эрх тэгш байдлыг хангах механизм, зохицуулалтын орчны талаарх мэдлэг, ойлголт, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт хийх чадавхаа дээшлүүллээ.

### Бичил уурхайчдын жендэр, хүний эрхийн мэдлэг, ойлголтыг гүнзгийрүүлэх сургалт зохион байгуулав



planetGOLD төсөл, МОНФЕМНЕТ үндэсний сүлжээ хамтран Говь-Алтай, Ховд, Сэлэнгэ аймгуудын бичил уурхайчдыг жендэр, хүний эрхийн идэвхтнээр бэлдэх 5 өдрийн сургалтыг 5-р сард зохион байгууллаа. Уг сургалт нь төслийн бүс нутгийн бичил уурхайчдын жендэр, хүний эрхийн талаар мэдлэг ойлголтыг гүнзгийрүүлэх, жендэр, хүний эрхийн

идэвхтэн бэлдэх, улмаар төлийн хүрээнд байгуулагдах Бичил уурхайн жендэрийн зөвлөлийн эхлэлийг тавихад дэмжлэг болов. Бичил уурхайчид МОНФЕМНЕТ үндэсний сүлжээгээс SASA! аргачлалын сургалт авч, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, Монголын эмэгтэйчүүдийн сан, Эрдэс баялаг эмэгтэйчүүд холбоо болон planetGOLD төлийн багийн ажилтай танилцлаа. Мөн энэ сургалтаар дамжуулан бичил уурхайчид хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй хариуцлагатай уурхайг таниулан сурталчилдаг, өрт тулгамдсан асуудлаар дуу хоолойгоо өргөдөг, нэгдмэл эрх ашгийг хамгаалахын төлөө үүрэг хүлээж ажилладаг жендэр, хүний эрхийн идэвхтнүүд болж бэлтгэгдлээ.

# Хурал, үзэсгэлэн



## Анхны үнэт металлын хурал, үзэсгэлэнг хамтран зохион байгуулав

Үнэт эдлэл, үнэт метал, гоёл чимэглэлийн салбарын хамгийн том нэгдсэн үзэсгэлэн, форум 4-р сард Монгол Улсад анх удаа зохион байгуулагдсан бөгөөд planetGOLD Монгол төсөл хамтран зохион байгуулагчаар оролцлоо. Гурван өдөр үргэлжилсэн энэхүү арга хэмжээнд ашигт малтмалын салбарын төрийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшил зэрэг олон байгууллагууд оролцлоо. Үзэсгэлэнгээр PlanetGOLD Монгол төлийн хамт олон алтны бичил уурхайчдын эрх үүрэг, бодит байдлын тухай олон нийтэд дэлгэрэнгүй танилцуулсан бол хуралд оролцогч талуудад албажуулалтын ач холбогдол, алтны гарал үүсэл, худалдааны сүлжээний ил тод байдал, санхүүгийн хүртээмж зэрэг сэдвүүдээр илтгэл тавьж мэдээлэл түгээв. planetGOLD Монгол төсөл Үнэт металлын хурал, үзэсгэлэнд хэрхэн оролцсон тухай дэлгэрэнгүй мэдээллийг Нийтлэл хэсэг дээр дарж уншина уу.

Нийтлэл

## "Мөнгөн усны чимээгүй аюул" гэрэл зургийн үзэсгэлэн Говь-Алтай аймагт зохион байгуулав



planetGOLD төсөл, БОАЖЯ-ны харьяа Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв, Говь-Алтай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар хамтран “Мөнгөн усны чимээгүй аюул, Минаматагийн конвенц” гэрэл зургийн үзэсгэлэнг 4-р сард Говь-Алтай аймгийн Алтай хотод зохион байгууллаа. Уг үзэсгэлэнгээр дамжуулан Минамата өвчин, мөнгөн усны химийн хор төдийгүй хүний эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөний

талаар гэрэл зургаар үзүүлж нийт 400 гаруй хүн үзэсгэлэнг үзэж сонирхов. Мөнгөн усны агаар, ус, хөрсөн дэх ялгарлыг бууруулахаар дэлхийн 137 орон Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцод нэгдэн орсон бөгөөд Монгол Улс 2015 онд уг конвенцыг соёрхон баталснаар алтны бичил уурхай дахь мөнгөн усны хэрэглээг бууруулах үүрэг амлалт авсан билээ. Дэлхийн байгаль орчны сангаас Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцид нэгдсэн улс орнуудад бичил уурхайд мөнгөн усны хэрэглээг бууруулахад нь туслах зорилгоор planetGOLD хөтөлбөрийг 23 улсад хэрэгжүүлж байгаагийн нэг нь Монгол Улс билээ.

# Уулзалт

## Этиопын төлөөлөгчид төслийн үйл ажиллагаатай танилцав



Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Этиоп Улсын Уул уурхайн яамны Бичил уурхайн салбар хариуцсан захирал Мэрга Кениа Гэмэдагаар ахлуулсан бичил уурхайн байгууллагууд болон SUMM төлийн төлөөлөгчид 2022 оны 5, 6-р сарuудад манай улсын бичил уурхайн эрх зүйн зохицуулалт, албажуулалт, туршлагаас суралцах зорилгоор айлчлал хийлээ. Уг айлчлалын хүрээнд planetGOLD төлийн хамт олон тус төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан бөгөөд уулзалтаар төлийн үйл ажиллагааг танилцуулахын зэрэгцээ харилцан туршлага солилцож, бичил уурхай дахь мөнгөн усны хэрэглээг бууруулах талаар хэлэлцүүлэг өнгөрүүллээ. Мөн Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, planetGOLD төсөл хамтран Монгол Улсын Алтны бичил уурхайн хууль эрх зүйн орчин, Хариуцлагатай бичил уурхайн талаар сургалт мөн зохион байгуулав.



## planetGOLD төсөл БОАЖЯ-тай хамтран мөнгөн усны тухай уулзалт зохион байгуулав

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, planetGOLD Монгол төсөл хамтран 2022 оны 6 дугаар сарын 7, 8-ны өдрүүдэд "Мөнгөн ус агуулсан бүтээгдэхүүн, түүнийг орлуулах боломж" болон "Бичил уурхай дахь мөнгөн усны хэрэглээ" сэдэвт уулзалт,

хэлэлцүүлэг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрчим хүчний яам, Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Экологийн цагдаагийн алба, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цаг уур орчны шинжилгээний газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, Говь-Алтай, Сэлэнгэ, Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар зэрэг байгууллагуудын мэргэжилтэн, судлаачид оролцлоо. Монгол Улс Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцыг 2015 онд соёрхон баталж, нэгдэн орсон билээ. Энэ хүрээнд салбаруудад хэрэглэгддэг мөнгөн ус агуулсан бүтээгдэхүүнийг орлуулах, алтны хүдэр боловсруулалтад ашиглаж байгаа мөнгөн усны хэрэглээг бууруулах үндэсний зорилгыг хэрэгжүүлж байгаа билээ. Энэ удаагийн уулзалтаар оролцогч талууд мөнгөн ус агуулсан бүтээгдэхүүнийг орлуулах боломжийг хэлэлцэж цаашид ямар арга хэмжээ авах талаар ярилцав. Мөн бичил уурхай дахь мөнгөн усны хэрэглээнээс үүдсэн эрүүл мэндийн нөлөө, бичил уурхайн албажуулалтын ач холбогдлын талаарх мэдээллийг өгч, хэлэлцүүлэг өнгөрүүллээ. Дашрамд дурдахад Дэлхийн мөнгөн усны үнэлгээгээр хүний үйл ажиллагаанаас хамааралтай мөнгөн усны ялгарлын 38% нь алтны бичил уурхайгаас ялгарч байгааг тогтоосон байдаг. Иймд Минаматагийн конвенцод алтны бичил уурхайд авч хэрэгжүүлэх стратеги, зохих арга хэмжээнүүдийг тусгасан байна. Бичил уурхайн асуудал нь нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлсээс хамаарч байдаг учраас мөнгөн усны хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулж буй эрсдэлийг бууруулахад салбар дундын зохицуулалт, бүх оролцогч талуудын хамтын ажиллагаа туйлын чухал юм.

# Бид олон улсын хуралд

planetGOLD Монгол төслийн менежер Exponential Climate Action Summit V хуралд оролцсон бичлэгийг 03:52:00-оос үзнэ үү

---

planetGOLD хөтөлбөрийн хуралд төслийн жендэрийн мэргэжилтэн илтгэл тавьсныг 01:36:00-аас үзнэ үү

---

planetGOLD хөтөлбөрийн хуралд төслийн технологич инженер илтгэл тавьсныг 02:40:00-өөс үзнэ үү

planetGOLD Mongolia | Санхүүжүүлэгч: gef | Үндсэн хэрэгжүүлэгч: UN environment programme | Хамтрагчид: UNIDO United Nations Industrial Development Organization; Монгол Улсын Засгийн газар Байгаль орчин, аялал жуулчлалын яам; AGC

Даян дэлхийн байгаль орчны сан-гийн санхүүжилтээр НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага хамтран хэрэгжүүлж буй planetGOLD Монгол төлийг Канад Улсын Алтны бичил уурхайн зөвлөл, Байгаль орчин, аялал жуулчлалын яам нар хамтран гүйцэтгэж байна.

Энэхүү мэдээллийн товхимлыг planetGOLD Монгол төслийн гол оролцогч талуудад илгээж байна.

Хэрвээ та цаашид и-мэйл хүлээн авах хүсэлгүй бол
доорх unsubscribe товч дээр дарна уу.

Unsubscribe